

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ГУЧИННЭГДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны аравдугаар сарын 06-ны 14 цаг 15 минутад эхэлж, 15 цаг 23 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 08 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35¹ дугаар зүйлийн 35¹.1.5, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулсан Сонгон шалгаруулах комиссын тайлан, дүгнэлтийг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Должингийн Баатарсайхан, Төмөрхуягын Сосорбарам, Доржийн Энхцэцэг нарыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх2. Энэ тогтоолын 1 дэх хэсгээр нөөцөд бүртгэгдсэн иргэдээс Должингийн Баатарсайханыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
2	Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын	Төрийн албаны тухай хуулийн 35

	<p>газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>дугаар зүйлийн 35.1.6, 35¹ дугаар зүйлийн 35¹.1.8, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулсан Сонгон шалгаруулах комиссын тайлан, дүгнэлтийг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1.Өлзийхутагийн Баянмөнхийг Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
3	<p>Төрийн албаны зөвлөлийн Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" мөн зөвлөлийн 2016 оны 118 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг</p>

		<p>тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1) Хил хамгаалах ерөнхий газрын дарга /Салбар зөвлөлийн дарга/ 2) Төрийн албаны төв байгууллагын төлөөлөл 3) Тэргүүн дэд дарга бөгөөд Хилийн цэргийн штабын дарга 4) Захиргааны удирдлага эрхэлсэн орлогч дарга 5) Ар тал, зэвсэглэл, инженер, техник эрхэлсэн орлогч дарга 6) Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын дарга 7) Мэргэжлийн удирдлагын газрын дарга 8) Захиргааны удирдлагын газрын дарга 9) Санхүүгийн хэлтсийн дарга, 10) Хүний нөөцийн хэлтсийн дарга /Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга/ <p>2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын “Хоёр”-ын 4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
4	Гаалийн ерөнхий газрын дэргэд Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл байгуулж, бүрэлдэхүүнийг батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны</p>

		<p>зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" мөн зөвлөлийн 2016 оны 118 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 06-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийг 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулах Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1) Гаалийн ерөнхий газрын дарга /Салбар зөвлөлийн дарга/ 2) Төрийн албаны төв байгууллагын төлөөлөл 3) Дэд дарга 4) Дэд дарга 5) Төрийн захиргааны удирдлагын газрын дарга 6) Гаалийн зөрчилтэй тэмцэх газрын дарга, 7) Хуулийн хэлтсийн дарга, 8) Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, 9) Хүний нөөцийн хэлтсийн дарга, 10) Салбар нэгжийн төлөөлөл 11) Төрийн захиргааны удирдлагын газрын гаалийн улсын байцаагч /Нарийн бичгийн дарга/ <p>3.2. Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Орон тооны гишүүн С.Цэдэндамбад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
5	<p>Архангай, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Архангай, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирүүлснийг хэлэлцээд, 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс</p>

		эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэв.
6	Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргыг томилох тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.13, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.5 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 115 тоот тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 01/6906 тоот албан бичгийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргаар Должингийн Баатарсайханыг 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн томилох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**